



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ж.Наранчимэг
Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 68
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА ХУРАНДАА
А.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага 2024 онд Улсын төсвөөс 8,434,389.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 1,793,266.8 мянган төгрөг нийт 10,227,655.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, улсын төсөвт 758,814.1 мянган төгрөг төвлөрүүлэн, төсвийн гүйцэтгэл 92.5 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 743,387.0 мянган төгрөгийн 9 тээврийн хэрэгслийг аймгийн Засаг даргын тамгын газар болон Цагдаагийн ерөнхий газраас шилжүүлэн авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/1866 дугаар "Шагнах тухай" тушаалын дагуу 238 албан хаагчдыг нийт 73,134,000 төгрөгөөр хавтгайруулан шагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль

D:\my doc \alban bichig\2025-A4.doc

тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3-д "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудал

Орхон аймгийн Цагдаагийн газар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Цагдаагийн ерөнхий газартай байгуулж, 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдсэн нь урд оноос 9.5 хувиар буурсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	448,253,723.60	401,858,298.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	133,849,181.85	102,417,921.28
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	133,849,181.85	102,417,921.28
3121	Төгрөг	133,849,181.85	102,417,921.28
31211	Төрийн сангийн харилцах	133,849,181.85	102,417,921.28
35	БАРАА МАТЕРИАЛ	314,404,541.75	299,440,377.45
351	Түүхий эд материал	179,245,539.05	188,191,139.05
35110	Тусгай зориулалттай материал	174,542,009.05	163,882,489.05
35130	Эм боох материал	4,703,530.00	24,308,650.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	58,682,160.00	7,378,360.00
354	Хангамжийн материал	51,642,738.70	64,357,877.40
35410	Бичиг хэргийн материал	8,719,856.00	12,310,107.50
35420	Аж ахуйн материал	11,797,320.00	10,725,180.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,980,000.00	1,122,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,296,855.20	14,304,282.90
35450	Барилгын засварын материал	3,251,000.00	6,758,000.00
35460	Хүнсний материал	0.50	1,326,500.00
35470	Бусад хангамжийн материал	21,597,707.00	17,811,807.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	24,834,104.00	39,513,001.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,863,841,691.75	4,884,465,785.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3863841691.75	4884465785.37
391	Газар		
392	Биет хөрөнгө	2,255,161,691.75	3,275,785,785.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,850,268,795.88	2,063,064,615.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	-255,236,056.84	-218,099,257.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	835,144,445.30	1,578,531,445.49
39204	Хуримтлагдсан элэгдэл	-670,120,144.15	-819,991,997.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	799,173,399.52	762,222,235.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-467,420,100.33	-221,167,460.86
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,457,518.90	69,836,567.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-71,257,969.89	-17,471,262.65
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	69,223,600.00	69,223,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,703,988.00	15,734,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,775,784.64	-6,097,000.56
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	425,000.00	425,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	-425,000.00	-425,000.00
39305	Газар эзэмших эрх	1,608,680,000.00	1,608,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,312,095,415.35</u>	<u>5,286,324,084.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,312,095,415.35</u>	<u>5,286,324,084.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,312,095,415.35	5,286,324,084.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,041,004,936.51	3,041,004,936.51
51101	Өмч: - төрийн	3,041,004,936.51	3,041,004,936.51
512	Хуримтлагдсан үр дүн	204,025,279.62	1,544,978,157.49
51210	Өмнөх үеийн үр дүн	204,025,279.62	570,749,488.74
51220	Тайлант үеийн үр дүн		974,228,668.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,067,065,199.22	700,340,990.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,312,095,415.35</u>	<u>5,286,324,084.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	13,676,000,673.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	3,448,344,809.08
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	3,448,344,809.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,448,344,809.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,913,157,950.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,535,186,859.08
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	10,227,655,864.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	8,434,389,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		8,434,389,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,793,266,864.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		63,614,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,729,652,864.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.00	12,652,740,627.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	12,652,740,627.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	10,827,250,547.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	9,376,279,532.96
210101	Үндсэн цалин		4,758,809,127.55
210102	Нэмэгдэл		2,187,552,692.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт		84,848,599.72
210104	Урамшуулал		1,066,528,046.67

210105	Гэрээт ажлын хөлс		1,278,541,066.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	227,138,207.01
210205	Эрүүл мэндийн даатгал		227,138,207.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	59,784,256.14
210301	Гэрэл, цахилгаан		17,440,163.07
210302	Түлш, халаалт		26,864,521.11
210303	Цэвэр, бохир ус		15,479,571.96
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	355,480,842.49
210401	Бичиг хэрэг		26,416,490.00
210402	Тээвэр, шатахуун		183,350,655.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		32,549,619.19
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		19,578,327.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		90,765,751.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/		
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		
2105	Нормативт зардал	0.00	75,507,681.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,337,080.00
210502	Хоол, хүнс		74,170,601.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	32,201,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		200,000.00
210604	Урсгал засвар		32,001,100.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	20,343,800.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		20,343,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	227,858,129.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		211,762,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		1,547,329.58
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		638,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,320,000.00
210807	Газрын төлбөр		12,348,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		242,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	452,656,998.24

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,585,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		444,071,398.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,825,490,079.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,066,675,892.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		90,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		808,257,915.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		48,833,977.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		209,493,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	758,814,187.69
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		686,178,937.69
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		72,635,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	0.00	1,023,260,045.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	49,031,376.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		176,198.60
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		48231178.12
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал		624000.00
230001	Эргэж төлөгдөх зээл		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-49,031,376.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	0.00	974,228,668.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0.00	12,184,356,953.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	1,956,701,089.43
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	1,956,701,089.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	1,956,701,089.43
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1913157950.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		43543139.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	10,227,655,864.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	8,434,389,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		8434389000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,793,266,864.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		63,614,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,729,652,864.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	0.00	12,203,530,214.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	12,203,530,214.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	10,367,380,526.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	9,380,867,894.25
210101	Үндсэн цалин		4,760,760,607.03
210102	Нэмэгдэл		2,190,189,574.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт		84,848,599.72
210104	Урамшуулал		1,066,528,046.67
210105	Гэрээт ажлын хөлс		1,278,541,066.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	245,800,482.06
210205	Эрүүл мэндийн даатгал		245,800,482.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	65,647,000.00
210301	Гэрэл, цахилгаан		18,068,500.00
210302	Түлш, халаалт		30,489,800.00
210303	Цэвэр, бохир ус		17,088,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	295,174,050.00
210401	Бичиг хэрэг		31,524,100.00
210402	Тээвэр, шатахуун		187,702,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		32,616,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		40,511,000.00
2105	Нормативт зардал	0.00	75,191,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,507,200.00
210502	Хоол, хүнс		72,883,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	41,197,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,242,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,000,000.00
210604	Урсгал засвар		33,955,600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	20,539,000.00
210702	Дотоод албан томилолт		20,539,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	232,242,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		216,286,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		1,649,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		638,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,320,000.00
210807	Газрын төлбөр		12,348,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	10,721,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,721,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,836,149,687.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,077,335,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		808,258,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		48,834,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		218,743,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	758,814,187.69
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		686,178,937.69
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		72,635,250.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	-19,173,260.57
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	12,258,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	12,258,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	12,258,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		12,258,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-12,258,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	-31,431,260.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		133,849,181.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	102,417,921.28

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3041004936.51	1067065199.22	204025279.62	0.00	4,312,095,415.35

D0 1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,041,004,936.51	1,067,065,199.22	204,025,279.62	0.00	4,312,095,415.35
D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			366,724,209.12		366,724,209.12
D0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,041,004,936.51	1,067,065,199.22	570,749,488.74	0.00	4,678,819,624.47
D0 4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		366,724,209.12			366,724,209.12
D0 5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D0 6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D0 7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D0 8	Тайлант үеийн үр дүн			974228668.75		974,228,668.75
D0 9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,041,004,936.51	700,340,990.10	1,544,978,157.49	0.00	5,286,324,084.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,212,585,100.00	11,456,974,026.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,212,585,100.00	11,456,974,026.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,053,353,000.00	10,379,638,526.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,434,524,500.00	9,380,867,894.25
210101	Үндсэн цалин	4,841,063,300.00	4,760,760,607.03
210102	Нэмэгдэл	2,597,086,300.00	2,190,189,574.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,000,000.00	84,848,599.72

210104	Урамшуулал	1,216,281,300.00	1,066,528,046.67
210105	Гэрээт ажлын хөлс	697,093,600.00	1,278,541,066.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,699,100.00	245,800,482.06
210205	Эрүүл мэндийн даатгал	222,699,100.00	245,800,482.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,524,700.00	65,647,000.00
210301	Гэрэл, цахилгаан	20,789,600.00	18,068,500.00
210302	Түлш, халаалт	35,222,400.00	30,489,800.00
210303	Цэвэр, бохир ус	18,512,700.00	17,088,700.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	202,502,500.00	295,174,050.00
210401	Бичиг хэрэг	29,439,800.00	31,524,100.00
210402	Тээвэр, шатахуун	153,363,400.00	187,702,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,144,500.00	32,616,200.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,820,000.00	2,820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,734,800.00	40,511,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	5,287,200.00	75,191,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	337,200.00	1,507,200.00
210502	Хоол, хүнс	3,900,000.00	72,883,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,874,900.00	53,455,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,690,000.00	17,500,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,166,700.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	34,018,200.00	33,955,600.00
2107	Томилолт, зочны зардал	21,885,800.00	20,539,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	21,885,800.00	20,539,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,666,400.00	232,242,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,710,500.00	216,286,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,649,500.00	1,649,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638,000.00	638,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	12,348,400.00	12,348,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,387,900.00	10,721,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,387,900.00	10,721,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,159,232,100.00	1,077,335,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,159,232,100.00	1,077,335,500.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,625,000.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,008,258,100.00	808,258,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	48,834,000.00	48,834,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,515,000.00	218,743,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,271,262,400.00	8,434,389,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,271,262,400.00	8,434,389,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,271,262,400.00	8,434,389,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн нийт зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй 2 зөрчилтэй асуудал нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

3.1 Төлбөрийн акт

3.2 Албан шаардлага

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин хөлс, урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийт төсвийн зарцуулалтын худалдан авсан бараа, ажил үйлчилгээний анхан шатны баримтад хяналт хэрэгжүүлэхэд худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын 6 дах хэсэг 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төлбөрийн баримтад бараа тус бүрээр оруулж тайлагнах.

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийн хугацаа хоцроож, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 6 тушаалыг орхигдуулж мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-

д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд мэлээллийг иж бүрэн байршуулах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт төсвийн зарцуулалтын худалдан авсан бараа, ажил үйлчилгээний анхан шатны баримтад хяналт хэрэгжүүлэхэд худалдан авч орлогоор бүртгэсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үнийн дүнг цахим төлбөрийн баримтад нийт дүнгээр бүртгэсэн байна	1	0					1	0				
Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийн хугацаа хоцроож, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч,	1	0					1	0				

хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 6 тушаалыг орхигдуулж мэдээлсэн байна.												
Дүн	2	0					2	0				